



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Түмэнцогт Ус- Дулаан ОНӨААТҮГ 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СБА-2025/018/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт хот 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Даваа Утас: 70518396 Аудитын менежер: М.Нарантуяа Утас: 70512123 Аудитор: Б.Мөнхбамбар Утас: 70512123</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518396
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2025.03.17 № 294
танай _____-ны № _____-г

СҮХБААТАР АЙМГИЙН ТҮМЭНЦОГТ
СУМЫН ТҮМЭНЦОГТ УС ДУЛААН
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Э.ОТГОНТӨГС ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Түмэнцогт ус дулаан ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бид дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлого үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 9 дүгээр тогтоолоор байгууллагын дүрэмд өөрчлөлт оруулсан бөгөөд Сүхбаатар аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2023 оны А/16 тоот тогтоолоор үйлчилгээний үнэ тарифт өөрчлөлт оруулсан байна.

Аудитын гол асуудал

Түмэнцогт ус дулаан ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлангаар 39.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Энэ нь халаалт дулаан болон төлбөрт үйлчилгээний үнийг шинэчлэн тогтоосон, зардлыг оновчтой төлөвлөж, хэмнэлт гаргасан нь нөлөөлжээ.

Бусад асуудал

Түмэнцогт ус дулаан ОНӨААТҮГ-ын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулж, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, тодруулга нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		2024 оны 01-р сарын 01	2024 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,573,506.36	12,242,892.81
1.1.2	Дансны авлага	12,476,520.63	19,758,637.15
1.1.6	Бараа материал	15,522,495.00	25,228,635.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	31,572,521.99	57,230,164.95
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,647,000,624.20	1,627,048,313.29
1.2.2	Биет бус хөрөнгө	14,192,000.00	14,192,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,661,192,624.20	1,641,240,313.29
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,692,765,146.18	1,698,470,478.25
2.1.1.1	Дансны өглөг	40,576,360.99	567,801.70
2.1.1.3	Татварын өр	24,883,693.62	10,553,085.14
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	260,544,018.05	296,756,404.93
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	326,004,072.66	307,877,291.77
2.2	Өр төлбөрийн нийт дүн	326,004,072.66	307,877,291.77
2.3.1	Өмч: - төрийн	2,959,592,416.76	2,959,592,416.76
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,608,706,029.06)	(1,568,999,230.28)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	1,350,886,387.70	1,390,593,186.48
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	1,692,765,146.18	1,698,470,478.25

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар		Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	380,862,210.26	572,575,880.48
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	315,637,528.06	350,824,604.54
3	Нийт ашиг (алдагдал)	65,224,682.20	221,751,275.94
10	Ерөнхий ба удирдлагын зардал	104,535,409.77	177,538,811.16
11	Санхүүгийн зардал	1,289,500.00	80,800.00
12	Бусад зардал	0.00	13,000.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(40,600,227.57)	44,118,664.78
19	Орлогын татварын зардал	0.00	4,411,866.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(40,600,227.57)	39,706,798.78
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(40,600,227.57)	39,706,798.78
24	Орлогын нийт дүн	(40,600,227.57)	39,706,798.78

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2023 оны 1-р сарын 1-н үлдэгдэл	1,277,836,426.90	0.00	0.00	1,681,755,989.86	0.00	0.00	(1,568,105,801.49)	1,391,486,615.27
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
2024 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	1,277,836,426.90	0.00	0.00	1,608,706,029.06	0.00	0.00	(1,608,706,029.06)	1,350,886,387.70
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	39,706,798.78	39,706,798.78
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,277,836,426.90	0.00	0.00	1,608,706,029.06	0.00	0.00	(1,568,999,230.28)	1,390,593,186.48

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	402,166,532.75	617,468,264.16
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	393,780,732.75	616,358,264.16
	Бусад мөнгөн орлого	8,385,800.00	1,100,000.00
1.2	Мөнгөн зарлага (-)	399,629,402.72	606,748,877.71
	Ажиллагчдад төлсөн	135,105,743.32	221,294,137.39
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	49,215,217.17	54,452,593.33
	Бараа материал худалдан авахад төлсөн	55,913,673.00	138,244,290.96
	Ашиглалтын зардалд төлсөн	39,451,698.11	31,939,674.95
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	92,401,804.00	68,297,419.00
	Хүүгийн төлбөрт төлсөн	1,200,000.00	
	Татварын байгууллагад төлсөн	14,503,942.12	86,351,891.70
	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	405,087.00
	Бусад мөнгөн зарлага	11,837,325.00	5,763,783.38
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,537,130.03	10,719,386.45
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	850,000.00	2,050,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	850,000.00	2,050,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(850,000.00)	(2,050,000.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,687,130.03	8,669,386.45
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,886,376.33	3,573,506.36
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,573,506.36	12,242,892.81

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	хэмжих нэгж	2024 он	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	гкал	3.82	3.79
2	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн тоо	ш	180.00	182.00
	-айл өрхийн тоо	ш	159.00	161.00
	-Албан байгууллагын тоо	ш	21.00	21.00

3	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн үнэ	төг	2,420.00	2,420.00
4	Нийт орлого	мян.төг	560,285.10	572,575.80
	цэвэр борлуулалт	мян.төг	560,285.10	572,575.80
5	Нийт зардал	мян.төг	552,961.30	528,363.40
	Үүнээс: удирдлагын зардал	мян.төг	165,780.00	177,538.80
6	Татварын өмнөх ашиг	мян.төг	7,323.8	44,212.4
7	Цэвэр ашиг (алдагдал)	мян.төг	7,250.50	39,791.40
8	Төсвийн төлбөр		2,420.00	2,420.00
10	Нийт авлага	мян.төг	8,560.50	19,758.60
13	Ажиллагсдын тоо	мян.төг	16	16
14	Цалингийн сан	мян.төг	241,770.40	247,500.30
15	Нийт хөрөнгийн дүн	мян.төг	1,692,765.10	1,698,470.40
16	-эргэлтийн хөрөнгө	мян.төг	29,924	57,230
	үүнээс бараа материал	мян.төг	9,850	25,229
17	-үндсэн хөрөнгө	мян.төг	1,692,765.10	1,698,470.40